

ГЕОДЕЗИЙН СУРГАЛТЫН ПОЛИГОН

Геодезийн сургалтын полигон нь хан хэнтийн дархан цаазат горхи, тэрэлжийн байгалийн цогцолбор газарт өвөр горхийн аманд орших бөгөөд улаанбаатар хотоос 65 км зайд байрладаг (зураг 1).



Зураг 1. Горхийн сургалтын полигон

Энэ полигоныг анх 1970 онд геодезийн сургалтын дадлагыг явуулах зорилгоор байгуулсан юм. Горхийн сургалтын полигон дээр анхны геодезийн сүлжээг 1983 онд триангуляцийн 2-р ангийн нарийвчлалаар орон нутгийн солбицол, өндрийн тогтолцоонд байгуулж, сургалтын ажилд хэрэглэж эхэлсэн болно.

Горхийн сургалтын полигон нь нэг дор 100 оюутан хүлээн авах хүчин чадалтай 8 өрөө бүхий 2 байр, багш нарын өрөө, багажийн болон хичээлийн тус бүр 1 өрөөтэй.



Зураг 4. Оюутны байр

Горхийн сургалтын полигон нь ой мод, хад асга, уул нуруу хосолсон байгалийн үзэсгэлэнт газар орших тул цэвэр агаартай, усан болорын олборлолт явуулж байсан агуйтай, гүний цэнгэг ус бүхий худагтай, үүрэн холбооны сүлжээтэй, оюутнуудын хичээллэх, амрах орчин бүрдсэн дадлагын бааз болж чадсан юм.